

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД НЭР
ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН ГАРГАХ,
ЗАРДЛЫН ТАЙЛАНД АУДИТ ХИЙХ, ХЯНАХ, ДҮНГ НИЙТЭД
МЭДЭЭЛЭХ, ТАНИЛЦУУЛАХ ЖУРАМ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Нэг. Журмын зорилго

1.1. Энэ журмын зорилго нь Монгол Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилтээ хуулиар хүлээн зөвшөөрсөн, бодитой эх үүсвэрээс бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулсан талаар тайлагнах, түүнд дүгнэлт гаргах, сонгуулийн санхүүжилтийг сонгогч иргэн, олон нийтэд нээлттэй, ил тод байлгах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хоёр. Журмын үйлчлэх хүрээ

2.1. Энэ журмыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч сонгуулийн санхүүжилтийн хөрөнгийг хуримтлуулах, сонгуулийн зардал гаргах, сонгуулийн зардлын тайлан гаргах, сонгуулийн зардлын тайландаа аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулах, Төрийн аудитын дээд байгууллагаас сонгуулийн зардлын тайланг хянаж, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулахад дагаж мөрдөнө.

2.2 Энэхүү журам нь 17.1-д заасан маягт, 19.7-д заасан дүгнэлтийн загвар бүхий хавсралтаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ

Гурав. Сонгуулийн зардлын данс

3.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн /цаашид “хууль” гэх/ 46.1-д зааснаар сонгуульд оролцож байгаа нам, эвсэл нь улсын хэмжээнд сонгуулийн зардлын төгрөгийн нэг данстай байна.

3.2 Нам, эвсэл нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 13-аас доошгүй хоногийн өмнө төрийн аудитын дээд байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй.

3.3. Сонгуулийн зардлын дансанд хуримтлагдах хөрөнгийн хэмжээнд тусгайлан хязгаар тогтоохгүй боловч тухайн сонгуулийн сурталчилгааны хугацаанд сонгуулийн

зардлын данснаас зарцуулах зардлын хэмжээ нь тогтоосон сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтрэхгүй.

3.4.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд тусгайлан зааснаас бусад хугацаанд сонгуулийн зардлын дансаа битүүмжлүүлэх бөгөөд зөвхөн орлого оруулахыг зөвшөөрнө.

3.5.Сонгуулийн зардлын дансны зарлагын битүүмжлэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд заасан хугацаагаар нээж өгөх хүсэлтийг нэр дэвшигчийг бүртгэсэн тухай Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийн хамт банканд хүргүүлснээр тухайн банк сонгуулийн зардлын дансны битүүмжлэлийг нээнэ.

Дөрөв. Сонгуулийн зардлын санхүүжилт

4.1.Нам, эвслийн сонгуулийн санхүүжилт нь намын өөрийн хөрөнгө, мөнгөн хандиваас бүрдэнэ.

4.2.Нам, эвслээс нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилт нь намын өөрийн хөрөнгө, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, мөнгөн ба мөнгөн бус хандиваас бүрдэнэ.

Тав. Сонгуулийн зардалд зарцуулах намын өөрийн хөрөнгө

5.1.Нам, эвсэл өөрийн нэр дэвшигчийн сонгуулийн зардалд зориулж олгох намын өөрийн хөрөнгийг нам, эвслийн сонгуулийн зардлын данснаас тухайн нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд шилжүүлэг хийж олгоно.

5.2. Нам, эвсэл сонгуулийн зардалд зарцуулах өөрийн хөрөнгийг бусдаас бэлэглэл, зээл хэлбэрээр авч бүрдүүлэхийг хориглоно.

Зургаа. Сонгуулийн зардалд зарцуулах нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө

6.1.Сонгуулийн зардалд зарцуулах нэр дэвшигчийн өөрийн хөрөнгөд Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан орлогод хамаарах мөнгөн хөрөнгө хамаарна.

6.2.Нэр дэвшигч энэ журмын 6.1-д заасан мөнгөн хөрөнгийг өөрийн данснаасаа сонгуулийн зардлын дансандаа байршуулж зарцуулна.

6.3.Нэр дэвшигч сонгуулийн зардалд зарцуулах өөрийн хөрөнгийг бусдаас бэлэглэл, зээл хэлбэрээр авч бүрдүүлэхийг хориглоно.

Долоо. Сонгуулийн хандив

7.1. Сонгуулийн хандив нь мөнгөн, мөнгөн бус хэлбэртэй байна.

7.2 Хандивлагч энэ хуульд заасан шаардлага хангасан, Монгол Улсын иргэн байна.

7.3 Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулиар хориглоогүй, түүнчлэн тухайн хуулийн этгээдийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хуулийн этгээд хандивлагч байж болно.

Найм. Мөнгөн хандив

8.1.Хандивлагч этгээдээс эргэж төлөх нөхцөлгүйгээр нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг мөнгөн хандив гэнэ.

8.2. Мөнгөн хандив нь иргэний хувьд гурван сая төгрөг хүртэл, хуулийн этгээдийн хувьд арван таван сая төгрөг хүртэл байна

8.3.Эвсэлд нэгдсэн намд сонгуульд зориулж хандив өгсөн бол тухайн намын нэгдэн орсон эвсэлд давхардуулан хандив өгөхийг хориглоно.

8.5.Бэлэн мөнгөөр хандив өгөх, авахыг хориглоно.

8.6.Нам, эвсэл, нэр дэвшигч нь мөнгөн хандивыг зөвхөн сонгуулийн зардлын дансанд хүлээж авна.

Ес. Мөнгөн бус хандив

9.1.Хандивлагч этгээдээс сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс дуусах хүртэл хугацаанд зөвхөн нэр дэвшигчид үнэ төлбөргүйгээр үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэх, үйлчилгээ үзүүлэхийг мөнгөн бус хандив гэнэ.

9.2. Мөнгөн бус хандив өгч байгаа тохиолдолд хандивлагч нь нэр дэвшигч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хандивын гэрээг бичгээр байгуулж гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулна.

9.3.Мөнгөн бус хандивыг сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс дуусах хүртэл хугацаанд зөвхөн нэр дэвшигчид өгнө.

Арав. Мөнгөн бус хандивын үнэлгээг тодорхойлох

10.1.Мөнгөн бус хандивын зах зээлийн дундаж үнэлгээг дараах журмаар тодорхойлно:

10.1.1.тухайн эд хөрөнгө ашиглуулсан, эзэмшүүлсэн, үйлчилгээ үзүүлсэн хандивлагч энэ төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг бол уг үйл ажиллагааны дундаж үнэлгээгээр;

10.1.2.тухайн эд хөрөнгө ашиглуулсан, эзэмшүүлсэн, үйлчилгээ үзүүлсэн хандивлагч энэ төрлийн аж ахуйн үйл ажиллагааг эрхэлдэггүй бол тухайн газар нутаг дахь энэ төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийн үнийн дундаж үнэлгээгээр.

10.2.Мөнгөн бус хандивын үнэлгээг зах зээлийн дундаж ханшийг үндэслэн хандивын гэрээгээр тогтоох бөгөөд уг үнэлгээ нь иргэн болон хуулийн этгээдээс өгөх хандивын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.

Арван нэг. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив

11.1.Дараах хандивыг хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивт тооцно:

11.1.1.банкны гүйлгээний баримтад хандивлагчийн нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл бүрэн тусгагдаагүй мөнгөн хандив;

11.1.2.буцах хаяг тодорхойгүй мөнгөн хандив;

11.1.3.хандив өгөхийг хориглосон этгээдээс өгсөн мөнгөн ба мөнгөн бус хандив;

11.1.4.хуульд заасан хэмжээнээс хэтэрсэн мөнгөн ба мөнгөн бус хандив.

11.2. Нэр дэвшигчид хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг хүлээн авч, зарцуулах, ашиглахыг хориглоно.

Тайлбар: Буцах хаяг тодорхойгүй мөнгөн хандив гэдэгт хандивлагчийн нэр, регистрийн дугаар, банкны дансны дугаар зэрэг мэдээлэл зөрүүтэй байхыг хамруулж ойлгоно.

Арван хоёр. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг буцаах, улсын орлогод шилжүүлэх

12.1.Нэр дэвшигч хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг дараах журмаар буцаан шилжүүлэх буюу улсын орлого болгоно:

12.1.1.энэ журмын 11.1.1, 11.1.3-т заасан мөнгөн хандивыг сонгуулийн зардлын тайлан гаргахаас өмнө хандивлагч этгээдэд буцаан шилжүүлэх;

12.1.2.энэ журмын 12.1.1-д заасан хугацаанд буцаан шилжүүлээгүй болон энэ журмын 11.1.2-т заасан мөнгөн хандивыг улсын орлого болгох;

12.1.3.энэ журмын 11.1.4-т заасан хандивыг улсын орлого болгох.

12.2.Нэр дэвшигч энэ журмын 12.1-д заасны дагуу улсын орлого болгох хандивыг улсын төсвийн орлогын нэгдсэн дансанд тушаана.

Арван гурав. Хуулиар зөвшөөрөгдөөгүй мөнгөн хандивыг ашигласанд тооцох

13.1.Нэр дэвшигч хуулиар зөвшөөрөгдөөгүй мөнгөн хандивыг сонгуулийн зардлын дансанд хүлээн авснаас хойших сонгуулийн зардлын дансны үлдэгдэл нь уг мөнгөн хандивын хэмжээнээс бага байж болохгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СОНГУУЛИЙН ЗАРДАЛ

Арван дөрөв. Сонгуулийн зардлын ангилал

14.1. Сонгуулийн зардлыг нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлалд заасан үзүүлэлтийг харгалзан ангилна.

14.2. Нэр дэвшигч сонгуулийн зардлыг дараах байдлаар ангилж, тайлагнана:

14.2.1. сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, тараах зардал;

14.2.2. нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал;

14.2.3. намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал;

14.2.4. сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал;

14.2.5. нэр дэвшигчийн ухуулах байр ажлуулах зардал;

14.2.6. сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал:

14.2.6.а. цалин хөлс, урамшууллын зардал;

14.2.6.б. нам, эвслээс зарцуулах томилолтын зардал;

14.2.6.в. сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардал.

14.2.7. сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал;

14.2.8. өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх зардал;

14.2.9. сонгуулийн сурталчилгаанд ашиглах тээврийн хэрэгслийн зардал

14.2.10. сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах зардал;

Арван тав. Сонгуулийн зардал гаргах

15.1. Нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэсэн өдрөөс эхэлж, сонгуулийн зардлын тайлан гаргах хүртэл хугацаанд энэ журмын 14.2-т заасан сонгуулийн зардалд зориулан сонгуулийн зардлын данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зарлага гаргана.

15.2. Нэр дэвшигчийн сонгуулийн зардлын данснаас гаргасан зарлага тус бүрийн зориулалт нь хүчин төгөлдөр анхан шатны баримтаар нотлогдсон байна.

15.3. Нэр дэвшигчид сонгуулийн зардлын данснаас бэлнээр зарлага гаргахыг хориглоно.

15.4. Намууд хамтарч сонгуульд оролцож байгаа бол сонгуулийн зардлын дансанд сонгуулийн зардал шилжүүлэхээс бусад зориулалтаар сонгуулийн зардлын

данснаас бие даан зарлага гаргахыг хориглоно. Эвслийн тухайд аймаг, нийслэл сум, дүүрэгт давхардсан данстай байж болохгүй.

15.5.Дараах зардлын нийт дүн нь сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтэрч болохгүй:

15.5.1.Сонгуулийн зардлын данснаас зарлага болгосон энэ журмын 14.2-т заасан зардлын дүн;

15.5.2.Сонгуулийн зардалтай холбоотой өр төлбөрийн дүн;

15.5.3.Мөнгөн бус хандивын хэмжээ /энэ заалт нь зөвхөн нэр дэвшигчид хамаарна/.

15.6.Энэ журмын 15.5-д заасан зардлын дүн нь сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд илүү гарсан хэсэгтэй тэнцэх хэмжээний мөнгөн төлбөрийг улсын орлого болгоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН

Арван зургаа. Сонгуулийн зардлын тайлан

16.1.Сонгуулийн зардлын тайланг мөнгөн ба мөнгөн бус гэж ангилна.

16.3.Сонгуулийн зардлын тайланд нэр дэвшигчийн сонгуульд зарцуулсан хөрөнгийн эх үүсвэр ба зарлагын мэдээллийг бүрэн тусгана.

Арван долоо. Сонгуулийн зардлын тайлан гаргах

17.1. Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт багтаан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах Маягт (1-10)-ын дагуу гаргаж, хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, Төрийн аудитын дээд байгууллагад ирүүлнэ.

17.2. Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч нь уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор Төрийн аудитын дээд байгууллагад ирүүлсэн байна.

17.3. Нам, эвсэл, нэр дэвшигч энэ журмын 17.1-д заасны дагуу Төрийн аудитын дээд байгууллагад ирүүлэх сонгуулийн зардлын тайландаа дараах баримт бичгүүдийг хавсаргасан байна:

17.3.1.сонгуулийн зардлын дансны хуулга;

17.3.2.сонгуулийн зардлын тайланд тусгасан орлого, зарлагыг нотлох анхан шатны баримт;

17.3.3.байгуулсан гэрээ, хэлцлийн хуулбар;

17.3.4.нэр дэвшигч мөнгөн бус хандив авсан бол хандивын гэрээний хуулбар, хандивын гэрээний үнэлгээг тодорхойлсон нотлох баримт.

Арван найм. Төрийн аудитын дээд байгууллага сонгуулийн зардлын тайланг хянах, дүнг мэдээлэх

18.1. Төрийн аудитын дээд байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлнэ.

18.2 Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.

18.3. Төрийн аудитын дээд байгууллага энэ журмын 17.1-д заасны дагуу ирүүлсэн нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг цахим хуудастаа байршуулж, хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайланг ирүүлээгүй нам, эсвэл, нэр дэвшигчийг нийтэд мэдээлнэ.

Арван ес. Аудитын хуулийн этгээд сонгуулийн зардлын тайланд дүгнэлт гаргах

19.1. Нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд аудит хийх аудитын хуулийн этгээд нь Аудитын тухай хуульд заасны дагуу ажил төрөл, хувийн харилцаа холбоо, ашиг сонирхлын хувьд нам, эвсэл, нэр дэвшигчээс хараат бус байх шаардлагыг хангасан байна.

19.2. Сонгуулийн зардлын тайланд аудит хийх аудитын хуулийн этгээд нь нам, эвсэл, нэр дэвшигчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээ байгуулж ажиллана.

19.3. Аудитын хуулийн этгээд сонгуулийн зардлын тайланд хийх аудитыг тухайн нэр дэвшигчээс энэ журмын 17.1-д заасан маягтын дагуу гаргасан тайлан, энэ журмын 17.3-т заасан баримт бичиг болон анхан шатны баримтад үндэслэн хийнэ.

19.4.Холбогдох нам, эвсэл, нэр дэвшигч нь аудитын хуулийн этгээдээс шаардсан баримт бичиг, мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж өгөх, эсхүл гуравдагч этгээдээс гаргуулж өгөх, аудитын үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоогоор хангах үүрэгтэй.

19.5. Аудитын хуулийн этгээд дараах асуудлуудын хүрээнд сонгуулийн зардлын тайланд аудит хийж дүгнэлт гаргана:

19.5.1. сонгуулийн зардлын тайланг батлагдсан маягтын дагуу иж бүрэн гаргаж, баталгаажуулсан эсэх;

19.5.2. сонгуулийн зардалд зарцуулсан нам, эвслээс нэр дэвшигчийн өөрийн хөрөнгийн эх үүсвэр нь тодорхой, бодитой эсэх;

19.5.3. хүлээн авсан мөнгөн хандив нь хуулиар зөвшөөрөгдсөн, эх үүсвэр нь тодорхой, бодитой эсэх;

19.5.4. хүлээн авсан мөнгөн бус хандивын үнэлгээг бодитой тодорхойлсон эсэх;

19.5.5. сонгуулийн зардлын тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв тусгагдсан эсэх;

19.5.6. сонгуулийн зардлын зарцуулалт зориулалтын дагуу бодитой хийгдсэн бөгөөд анхан шатны баримтыг үндэслэн сонгуулийн зардлын тайланд үнэн зөв тусгагдсан эсэх.

19.6. Аудитын хуулийн этгээд сонгуулийн зардлын тайланд аудит хийхдээ Аудитын олон улсын стандартыг баримталж, Аудитын олон улсын стандарт 800 “Тусгай зорилго бүхий үзэл баримтлалд нийцүүлэн бэлтгэсэн санхүүгийн тайлангийн аудит”-г удирдлага болгон Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан загварын дагуу дүгнэлт гаргана.

19.7. Аудитын хуулийн этгээд аудитын явц үр дүн болон энэ журмын 19.7-д заасан дүгнэлтэд дэмжлэг болгох зорилгоор дараах бүтэц, агуулга бүхий аудитын дэлгэрэнгүй тайлан, дүгнэлтийн хамт төрийн аудитын дээд байгууллагад ирүүлнэ:

19.7.1. аудит хийсэн үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага;

19.7.2. аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт;

19.7.3. тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал;

19.7.4. материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар;

19.7.5. аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн;

19.7.6. илрүүлсэн зүйлсийн нэгтгэл, тайлбар;

19.7.7. санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД ЗААЛТ

Хорь. Сонгуулийн зардлын ил тод байдлыг хангахад иргэд, олон нийтийн байгууллагын оролцоо

20.1. Сонгуулийн зардлын ил тод байдлыг хангахад иргэд, олон нийтийн байгууллага дараах оролцоотой байна:

20.1.1. сонгуулийн зардлын ил тод байдлыг хангахад чиглэсэн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавихад оролцох, хөндлөнгийн ажиглалт хийх;

20.1.2. сонгуулийн зардалтай холбоотой гарсан зөрчил, гэмт хэргийн шинжтэй үйлдлийн талаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагад гомдол, мэдээлэл гаргах;

20.1.3. нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг үнэн зөв, бодитой гаргасан эсэх талаар дүн шинжилгээ хийх, санал, зөвлөмж гаргах.

Хорин нэг. Хариуцлага

21.1. Төрийн аудитын дээд байгууллага нь сонгуулийн зардлын тайлангийн аудитын дүгнэлтийг үнэн зөв, бодитой гаргаагүй, илт худал дүгнэлт гаргасан, эсхүл хуульд заасныг зөрчиж аудит хийсэн аудитын хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлнэ.

21.2. Төрийн аудитын дээд байгууллага сонгуулийн зардлын тайлантай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйл ажиллагаа, баримт илэрсэн тохиолдолд энэ тухай мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж шалгуулна.

21.3. Төрийн аудитын дээд байгууллагын нь аудитын хуулийн этгээдийн гаргасан дүгнэлт, түүний мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг Төрийн аудитын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд зааснаар шийдвэрлэнэ.

Монгол Улсын Ерөнхий аудиторов 20...
оны __ сарын __ өдрийн __ дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

**ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИЙН ЗАРДЛЫН
ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ**

Маягт-1

Тайлан ирүүлсэн огноо:

... оны ...-р сарын ...-ны өдөр

Тайлангийн төрөл:

НЭГ. НЭР ДЭВШИГЧИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ		
Ургийн овог:		
Эцэг /эх/-ийн нэр:		
Өөрийн нэр:		
Регистрийн дугаар:		
ХОЁР. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ		
Сонгуулийн зардлын данс нээлгэсэн банкны нэр:		
Дансны дугаар:		
Гүйлгээ хийж эхэлсэн огноо:	... оны ...-р сарын ...-ны өдөр	
Хамгийн сүүлд гүйлгээ хийсэн огноо:	... оны ...-р сарын ...-ны өдөр	
Эхний үлдэгдэл:		
ГУРАВ. НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН		
Үзүүлэлт	Хэмжээ /төгрөгөөр/	Тоо
1. НИЙТ ОРЛОГЫН ДҮН		
1.1 Нам/эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө		
1.2 Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө		
1.3 Хуулийн этгээдийн өгсөн нийт хандив		
1.3.1 Мөнгөн хандив		
1.3.2 Мөнгөн бус хандив		
1.4 Иргэний өгсөн нийт хандив		
1.4.1 Мөнгөн хандив		
1.4.1 Мөнгөн хандив		
2. НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		
2.1 Сонгуулийн зардал		
2.1.1 сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал		
2.1.2 сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах		
2.1.3 нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал		
2.1.4 намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал		

2.1.5 сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал		
2.1.6 Ухуулах байр ажлуулах зардал		
2.1.7 сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах		
2.1.8 цахим орчин ашиглах зардал		
2.1.9 өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх зардал		
2.1.10 Сонгуулийн сурталчилгаанд тээврийн хэрэгсэл ашиглах зардал		
3. ҮЛДЭГДЭЛ		
4. ҮЛДЭГДЛИЙН БАЙРШИЛ		
5. ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙГАА ӨР ТӨЛБӨР		
6. ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВ		
6.1 буцаасан дүн		
6.2 улсын орлого болгосон		
(Анхаарах: Дээрх бүх мэдээлэл дансны хуулгаар баталгаажна)		

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

/Овог нэр/

/Албан тушаал/

ТАЙЛАН ХЯНАСАН:

/Овог нэр/

/Албан тушаал/

НАМ ЭВСЛЭЭС НЭР ДЭВШИГЧИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ТАЙЛАН

Нэр дэвшигчийн нэр _____

/Маягт-2/

№	Дансны дугаар, банкны нэр	Мөнгөн дүн	Огноо	Эх үүсвэр
1.				
2.				
3.				
Нийт дүн				

Заавар: Мөнгөн дүн, огноо, эх үүсвэрийг гүйлгээ тус бүрээр нэг бүрчлэн бичнэ. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын дансандаа төвлөрүүлсэн нам, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгийг ямар эх үүсвэрээс бүрдүүлсэн талаараа үнэн зөв, тодорхой бичнэ.

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/
/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/
/албан тушаал /

МӨНГӨН ХАНДИВЫН ТАЙЛАН

Нэр дэвшигчийн нэр _____

/Маягт-3/

№	Хандивлагч		Хандивын хэмжээ /төгрөг/	Хандивын эх үүсвэр*	Хандивласан огноо
	Нэр	Регистрийн дугаар			
1.	Иргэн				
2.					
3.					
		Дүн			
1.	Хуулийн этгээд				
2.					
3.					
		Дүн			
	Нийт дүн				

*Хандивын эх үүсвэрийн мэдээллийг зөвхөн банкны гүйлгээний баримтад тусгагдсан байдлаар бичнэ.

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/

/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/

/албан тушаал /

МӨНГӨН БУС ХАНДИВЫН ТАЙЛАН

Нэр дэвшигчийн нэр _____

/Маягт-4/

№	Хандивлагч		Хандивлагчийн хаяг	эд хөрөнгө болон авсан үйлчилгээний мэдээлэл, хандивын зориулалт*	Гэрээний дугаар	Хандивын хэмжээ /хандивын гэрээнд зааснаар/	огноо
	Нэр	Регистрийн дугаар					
1.	Иргэн						
2.							
3.							
	Дүн						
1.	Хуулийн этгээд						
2.							
3.							
	Дүн						
	Нийт дүн						

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/

/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/

/албан тушаал /

*Эзэмшүүлсэн, ашиглуулсан эд хөрөнгө нь үл хөдлөх эд хөрөнгө тохиолдолд улсын бүртгэлийн дугаар, тээврийн хэрэгсэл тохиолдолд улсын дугаар, бусад хөдлөх эд хөрөнгө тохиолдолд хөрөнгийн марк, нэр, эд хөрөнгө эзэмшсэн, ашигласан, авсан үйлчилгээний зориулалтыг тодорхой бичнэ.

Мөнгөн бус хандивын хэмжээг тодорхойлох жишээ:

- Оффисын тоног төхөөрөмж түрээслэх бизнес эрхэлдэггүй этгээд дэвшигчид сонгуулийн сурталчилгааны ажилд нь хувилагч машин үнэ төлбөргүйгээр ашиглуулжээ. Энэ тохиолдолд нэр дэвшигч тухайн орон нутаг дахь ийм төрлийн үйл ажиллагаа явуулдаг этгээдээс уг тоног төхөөрөмжийг ашиглахад ямар хөлс төлөхийг судлах замаар мөнгөн бус хандивын үнэлгээг тодорхойлно.
- Оффисын тоног төхөөрөмж түрээслэх бизнес эрхэлдэг этгээд нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааны ажилд нь хувилагч машин үнэ төлбөргүйгээр ашиглуулсан тохиолдолд уг мөнгөн бус хандивын хэмжээг тухайн этгээд энэ төрлийн үйлчилгээ үзүүлээд авдаг хөлсний дундаж үнэлгээгээр тодорхойлно.

ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВЫН ТАЙЛАН

Нэр дэвшигчийн нэр _____

/Маягт-5/

№	Хандивлагч иргэн, хуулийн этгээдийн нэр /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Хандивлагчийн регистрийн дугаар /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Хандивын хэмжээ	Хандивын хэлбэр	Огноо	Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив гэж үзсэн тухай тайлбар
1.						
2.						
3.						
Нийт дүн						

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/
/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/
/албан тушаал /

**ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВЫГ БУЦААСАН БУЮУ УЛСЫН
ОРЛОГО БОЛГОСОН ТУХАЙ ТАЙЛАН**

Нэр дэвшигчийн нэр _____

/Маягт-6/

№	Хандивлагч иргэн, хуулийн этгээдийн нэр /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Хандивлагчийн регистрийн дугаар /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Хандив ын хэмжээ	Шилжүүлгийн мэдээлэл		Буцаасан, улсын орлого болгосон тухай тайлбар	Огноо
				Буцаасан	Улсын орлого болгосон		
1.							
2.							
3.							
Нийт дүн							

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/
/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/
/албан тушаал /

СОНГУУЛИЙН ЗАРДАЛТАЙ ХОЛБООТОЙ ӨГЛӨГИЙН ТАЙЛАН

Нэр дэвшигчийн нэр _____

/Маягт-7/

№	Зардлын зориулалтын тайлбар	Нэхэмжлэгч этгээдийн		Төлөх дүн	Төлөөгүй байгаа шалтгаан, цаашид авах арга хэмжээ
		Нэр	Регистрийн дугаар		
1.					
2.					
3.					
Нийт дүн					

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/
/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/
/албан тушаал /

СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДАНСНЫ ГҮЙЛГЭЭ ТУС БҮРЭЭР ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Нам / эвсэл / нэр дэвшигчийн нэр _____

/Маягт-8/

№	Баримтын			Харилцагчийн нэр	Гүйлгээний утга	Дүн	Үүнээс: Орлогын ангилал									Тайлбар
							Нам/эвслээс оруулсан мөнгөн хөрөнгө	Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	Иргэний өгсөн нийт хандив		Хуулийн этгээдийн өгсөн нийт хандив		Хандивын дансаар орсон бусад орлогын гүйлгээ			
	Огноо	Нэр	Дугаар						Мөнгөн хандив	Мөнгөн бус хандив	Мөнгөн хандив	Мөнгөн бус хандив	Нам, эсвэл, нэр дэвшигчийн хооронд шилжүүлсэн орлого	Банкны үйлчилгээ	Бусад	
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
				Дүн												

Тайлан гаргасан:

Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр, гарын үсэг, тамга

Хянаж баталгаажуулсан:

Аудитын хуулийн этгээдийн нэр, гарын үсэг, тамга

СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДАНСНЫ ГҮЙЛГЭЭ ТУС БҮРЭЭР ХИЙСЭН ЗАРЛАГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Нэр дэвшигчийн нэр _____

/Маягт-9/

№	Баримтын			Харилцагчийн нэр	Гүйлгээний утга	Дүн	Сонгуулийн зардлын ангилал													
							Сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал			сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах		Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах зардал	Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	Ухуулах байр ажлуулах зардал	Сонгуулийн сурталчилгаанд Радио, телевиз ашиглах зардал		Цахим орчин ашиглах зардал	Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	Сонгуулийн сурталчилгаанд тээврийн хэрэгсэл ашиглах зардал
	Огноо	Нэр	Дугаар				Цалин хөлс, урамшууллын зардал	Томилолтын зардал	сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардал	сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх зардал	сонгуулийн сурталчилгааны материал тараах, хүргэх зардал					Эх бэлтгэлийн зардал	Нэвтрүүлгийн зардал			
А	Б	В	Г	Д	Е	Ё	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
					Дүн															

Тайлан гаргасан:

Хянаж баталгаажуулсан:

Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр, гарын үсэг, тамга

Аудитын хуулийн этгээдийн нэр, гарын үсэг, тамга

ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр		А	тийм / үгүй/ мөнгөн дүн
Нэр дэвшигчийн мэдээлэл		Эцэг/эх/-ийн нэр	В
		Өөрийн нэр	Г
		Регистрийн дугаар	Д
Сонгуулийн зардлыг хэмжээг баримталсан эсэх	Нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 13-с доошгүй хоногийн өмнө мэдэгдэж, бүртгүүлсэн үү.	Тийм	1
		Үгүй	2
	Төрийн аудитын дээд байгууллагаас тогтоосон сонгуулийн тойрогт нэр дэвшигч, нам, эвслээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг баримталсан эсэх	Тогтоосон хэмжээ	3
		Зардлын гүйцэтгэл	4
		Зөрүү	5
Нэр дэвшигч өөрийн сонгуулийн зардалд зарцуулсан өөрийн хөрөнгийг сонгуулийн зардлын дансандаа байршуулалгүйгээр өөр дансанд төвлөрүүлж зардал гаргасан эсэх		Тоо	6
		Дүн /төгрөг/	7
Нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлэхгүйгээр бэлнээр зарцуулсан эсэх		Тоо	8
		Дүн /төгрөг/	9
Нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайланг хугацаанд нь ирүүлсэн эсэх		Тийм	10
		Үгүй	11
Нэр дэвшигч нь сонгуулийн зардлын эцсийн тайланг иж бүрэн ирүүлсэн эсэх		Тийм	12
		Үгүй	13
Сонгуулийн хандив хуульд заасан шаардлагыг хангасан эсэх	Иргэнээс өгсөн мөнгөн хандив хуульд заасан хэмжээнээс хэтэрсэн эсэх	Тоо	14
		Дүн /төгрөг/	15
	Хуулийн этгээдээс өгсөн мөнгөн хандив хуульд заасан хэмжээнээс хэтэрсэн эсэх	Тоо	16
		Дүн /төгрөг/	17
	Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл дутуу хандивыг хүлээн авагчид буцаан шилжүүлээгүй байх	Тоо	18
		Дүн /төгрөг/	19
	Буцах хаяг тодорхойгүй мөнгөн хандивыг улсын	Тоо	20

	орлого болгоогүй байх	Дүн /төгрөг/	21	
	Мөнгөн бус хандив өгч байгаа тохиолдолд хандивлагч нь нэр дэвшигч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй бичгээр хандивын гэрээ байгуулаагүй байх	Тоо	22	
		Дүн /төгрөг/	23	
	Хандив өгөхийг хориглосон этгээдээс өгсөн мөнгөн ба мөнгөн бус хандивыг хүлээн авах эрх бүхий этгээд буцаан шилжүүлээгүй байх	Тоо	24	
Дүн /төгрөг/		25		
Сонгуулийн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан эсэх	Сонгуулийн зардлын мөнгөн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх	Тоо	26	
		Дүн /төгрөг/	27	
Аудитын хуулийн этгээд сонгуулийн зардлын эцсийн тайланг үнэн зөв баталгаажуулсан эсэх	Сонгуулийн зардлын эцсийн тайланд аудит хийхээр нам, эвсэл, нэр дэвшигчтэй гэрээ байгуулсан аудитын хуулийн этгээд хараат бус байх шаардлагыг хангасан талаарх мэдэгдэл, тайлбараа гэрээ байгуулснаас хойш 2 хоногийн дотор ҮАГ-т мэдэгдсэн эсэх	Тийм	28	
		Үгүй	29	
	Сонгуулийн зардлын тайланг батлагдсан маягтын дагуу иж бүрэн гаргаж, баталгаажуулсан эсэх	Тийм	30	
		Үгүй	31	
	Аудитын хуулийн этгээд аудитын явц үр дүн болон аудитын дэлгэрэнгүй тайлан, дүгнэлтийг ирүүлсэн эсэх	Тийм	32	
		Үгүй	33	
Аудит хийсэн хуулийн этгээдийн нэр			34	

Анхааруулга: Хамааралгүй, тийм, үгүй гэсэн хариултуудаас тохирох хариуг харгалзах нүдэнд нь "1"-ийн тоогоор тэмдэглэнэ.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 20.... оны
__ сарын __ өдрийн __ дугаар тушаалын
гуравдугаар хавсралт

(НЭР ДЭВШИГЧИЙН НЭР)-Д

Хараат бус аудитын дүгнэлт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 20.... оны ээлжит сонгуульд оролцогч (*нэр дэвшигчийн нэр*)-ын сонгуулийн зардлын тайланд аудит хийж дүгнэлт гаргалаа.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр (*Нэр дэвшигчийн нэр*)-ын Монгол Улсын Ерөнхийлөгчийн 20..... оны ээлжит сонгуулийн зардлын тайлан, түүний тодруулга мэдээллүүд нь бүхий л материаллаг асуудлаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, тогтоомжийн дагуу үнэн зөв, иж бүрэн (*илэрхийлэгдсэн / илэрхийлэгдээгүй*) байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитыг Төрийн аудитын тухай хууль, Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-д заасан Төрийн аудитын дээд байгууллагын бүрэн эрхийн хүрээнд болон энэ хуулийн 53 дугаар зүйлийн 53.2.5-д заасан журмын дагуу Аудитын олон улсын стандарт, Монгол Улсын “Төрийн аудит MNS 6817 – (1-8): 2020” стандартыг тус тус удирдлага болгон гүйцэтгэлээ. Эдгээр стандарт шаардлагын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийн Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл хэсэгт харуулав.

Аудитаар сонгуулийн зардлын тайлан дах дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, чухал тооцооллыг үнэлж цэгнэн, зардлын тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудитаар сонгуулийн зардлын тайлан үнэн зөв, иж бүрэн, материаллаг (*алдаагүй / алдаатай*) илэрхийлэгдсэн гэж дүгнэв. Бидний хийсэн аудит **дүгнэлт** өгөх хангалттай үндэслэл болно гэж үзэж байна.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 20.... оны ээлжит сонгуульд оролцогч нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 52 дугаар зүйлд заасан Сонгуулийн зардлын тайланг энэ хууль болон холбогдох журмын дагуу бэлтгэж, хараат бус аудитын дүгнэлт гаргуулах үүрэгтэй.

Сонгуулийн зардлын тайлан, бусад тодруулга мэдээлэл Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн баталсан холбогдох журмын дагуу үнэн, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт гаргах нь аудитын байгууллагын үүрэг юм.

Хараат бус аудитын дүгнэлтэд /..... хуудас/ материал хавсаргав.

Хувийг: Үндэсний аудитын газарт

Гарын үсэг
Тамга тэмдэг